



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТӨВ БАЙГУУЛЛАГЫНДАРГА,
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 08 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар А/170/А/0138

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хуулийн 192 дугаар зүйлийн 192.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1."Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба /хурандаа Х.Ариунболд/-нд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхэд хөгжил, хамгааллын газар /Ц.Алтанзаяа/-д тус тус даалгасугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ
Ц.АМГАЛАНБАЯР

ГЭР БҮЛХҮҮХЭД,ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
О.АЛТАНСҮХ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга нарын хамтарсан 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/170/А/0138 дугаар тушаалын хавсралт

ХҮМҮҮЖЛИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, хяналт тавихад Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль бусад холбогдох хууль тогтоомж, энэ журмыг мөрдлөг болгоно.

1.2.Шийдвэр гүйцэтгэгч хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан өсвөр насны хүн /цаашид албадлагын арга хэмжээ авагдсан хүн гэх/-д тавих хяналтыг эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэснээс эхлэн албадлагын арга хэмжээ авагдсан хугацаа дуусах хүртэл хэрэгжүүлнэ.

1.3.Шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга, ахлах шийдвэр гүйцэтгэгч байнгын хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.

Хоёр. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг хүлээн авах, хуваарилах

2.1.Ахлах шийдвэр гүйцэтгэгч хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг албадлагын арга хэмжээ авагдсан хүний хамт шүүхээс хүлээн авч тоо бүртгэлд оруулан, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тухай тогтоол гаргаж, тойргийн шийдвэр гүйцэтгэгчид 3 хоногийн дотор хуваарилна.

2.2.Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоолыг хүлээн авсан даруйд албадлагын арга хэмжээ авагдсан хүнд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээж, түүнд албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журам, эрх, үүргийг танилцуулна.

2.3.Ахлах шийдвэр гүйцэтгэгч эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоолын хувийг прокурорт 3 хоногийн дотор хүргүүлнэ.

Гурав. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

3.1.Шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээ авагдсан хүн, хүмүүжүүлэх үүрэг бүхий асран хамгаалагч, харгазан дэмжигч, төрийн бус байгууллага, хамт олонд эрх, үүрэг болон шүүхээс хүлээлгэсэн үүрэг, түүнийг биелүүлэх хугацаа, хуваарийг нарийвчлан тусгасан мэдэгдлийг танилцуулан гарын үсэг зуруулж, биелэлтэд нь хяналт тавина.

3.2.Энэ зүйлийн 3.1-т заасан мэдэгдэлд заасан хугацаанд албадлагын арга хэмжээ авагдсан хүний асран хамгаалагч, хараа хяналтандаа байлгахыг зөвшөөрсөн иргэн, хуулийн этгээдийн төлөөлөгчийг дуудан ирүүлж, батлан даалт гаргуулж биелэлтийг хангуулна.

3.3.Шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээ авагдсан хүнтэй улирал тутам нэгээс доошгүй удаа уулзан, биеэр ирэх боломжгүй тохиолдолд хүмүүжүүлэх үүрэг бүхий асран хамгаалагч, харгалзан дэмжигч, төрийн бус байгууллага, хамт олны төлөөлөгчтэй утсаар холбогдон шүүхээс хүлээлгэсэн үүргийн биелэлтийн талаар хувийн хэрэгт тэмдэглэл үйлдэж, баяжилт хийнэ.

3.4.Шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээ авагдсан хүний оршин суух газар, сургууль өөрчлөгдсөн тухай болон шаардлагатай бусад мэдээллийн талаар хувийн хэрэгт тухай бүр тэмдэглэл үйлдэж, хавсаргана.

3.5.Шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээ авагдсан хүн шүүхээс хүлээлгэсэн үүргийг зөрчсөн талаар хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн мэдээллийг шалгана.

3.6.Албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуулийн 8.7.3, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 192 дугаар зүйлийн 192.1-т заасан байгууллага гүйцэтгэнэ.

3.7.Энэ зүйлийн 3.6-д заасан ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 192 дугаар зүйлийн 192.2-т заасны дагуу хяналт тавина.

Дөрөв. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийн биелэлтийг бусад байгууллагатай хамтран зохион байгуулах

4.1.Шийдвэр гүйцэтгэгч хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийн хувийг, энэ зүйлийн 3.1-т заасан мэдэгдлийн хамт албадлагын арга хэмжээ авагдсан хүний оршин суух газрын хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, цагдаагийн байгууллагад 7 хоногийн дотор хүргүүлнэ.

4.2.Шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээ авагдсан хүнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189.1-д заасан үүрэг, хугацаа, хуваарийг танилцуулна.

4.3.Хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь албадлагын арга хэмжээ авагдсан хүний сахилга, шүүхээс даалгасан үүрэг, засрал хүмүүжлийн байдлыг сард нэгээс доошгүй удаа шалган танилцаж, энэ талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст албан бичгээр мэдээлэл ирүүлнэ. Зөрчил илэрсэн тохиолдолд нэн даруй мэдэгдэнэ.

4.4.Шийдвэр гүйцэтгэгч холбогдох эрх бүхий байгууллагаас албадлагын арга хэмжээ авагдсан хүн Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил гаргасан эсэх талаарх лавлагааг улирал тутам авч хувийн хэрэгт хавсаргана.

4.5.Албадлагын арга хэмжээ авагдсан хүнд Сум, дүүргийн засаг дарга Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.5-д зааснаар зохих туслалцааг үзүүлнэ.

4.6.Хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас албадлагын арга хэмжээ авагдсан хүнд явуулах сургалт, хүмүүжлийн ажлын хөтөлбөр, төлөвлөгөөг батална.

4.7.Албадлагын арга хэмжээ авагдсан хүнд сургалт, хүмүүжлийн ажлыг батлагдсан хөтөлбөрийн дагуу тус байгууллагын хариуцсан нэгжийн ажилтан зохион байгуулж явуулна.

4.8.Хариуцсан нэгжийн ажилтан албадлагын арга хэмжээ авагдсан хүний нас бие, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогт тохирсон сургалтын төлөвлөгөөг боловсруулах бөгөөд түүнийг хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын нэгжийн дарга батална.

4.9.Хариуцсан нэгжийн ажилтан нь сар бүр албадлагын арга хэмжээ авагдсан хүний сургалт, хүмүүжлийн ажилд хамрагдсан байдлын талаарх баримтыг баталгаажуулан харьяа шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст албан бичгээр хүргүүлнэ.

4.10.Сургалт, хүмүүжлийн ажил батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явагдаж буй эсэхэд шийдвэр гүйцэтгэгч улирал тутам хяналт тавьж, тухай бүр прокурорт танилцуулна.

Тав. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан хүнд холбогдох баримт бичигт тавигдах шаардлага

5.1.Албадлагын арга хэмжээ авагдсан хүний эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэгт дараах баримт бичгийг хавсаргана:

5.1.1.шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоол;

5.1.2.албадлагын арга хэмжээ авагдсан хүний талаарх бүртгэл;

5.1.3.албадлагын арга хэмжээ авагдсан хүнд эрх, үүрэг танилцуулсан тэмдэглэл;

5.1.4.хараа хяналтандаа байлгахыг зөвшөөрсөн иргэн, хуулийн этгээдийн төлөөлөгчийн батлан даалт, баталгаа;

5.1.5.улирал тутам хяналт тавьсан талаарх тэмдэглэл;

5.1.6.Хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналт тавьсан талаар ирүүлсэн албан бичиг;

5.1.7.Хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан сургалт, хүмүүжлийн ажлын хөтөлбөр, төлөвлөгөө, түүний дагуу явагдсан сургалт, ажлын талаарх тэмдэглэл, холбогдох баримт бичиг;

5.1.8.Зөрчлийн тухай хууль болон бусад хууль, журам зөрчсөн тухай лавлагаа, тодорхойлолт, тэмдэглэл;

5.1.9.албадлагын арга хэмжээ дууссан тухай тогтоол;

5.1.10.албадлагын арга хэмжээ авагдсан хүнд хяналт тавих хуудас;

5.1.11.прокурорын хяналтын хуудас;

5.1.12.хувийн хэрэгтэй танилцсан хуудас;

5.1.13.бусад материал.

Зургаа. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний шилжилт хөдөлгөөнд хяналт тавих

6.1.Албадлагын арга хэмжээ авагдсан хүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас түр хугацаагаар /түр хугацааг 2 сар хүртэл хугацаагаар/ өөр орон нутагт явах бол шийдвэр гүйцэтгэгч үндэслэл бүхий бичиг баримтыг хувийн хэрэгт хавсарган очих хаяг, холбоо барих утас, бусад шаардлагатай мэдээллийг авч харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст бичгээр мэдэгдэж, мэдээлэл солилцож хяналт тавина.

6.2.Албадлагын арга хэмжээ авагдсан хүн түр хугацаанаас дээш хугацаагаар өөр орон нутагт оршин суухаар явсан, байнга оршин суух газраа өөрчилсөн бол холбогдох нотлох баримтыг үндэслэн шүүхээс даалгасан үүргийн биелэлтийн тооцоог хийж прокурорт хянуулан, шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх талаарх албан бичгийг, хувийн хэргийн хамт Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд даруй хүргүүлнэ.

Долоо. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан хүний албадлагын арга хэмжээг шийдвэрлүүлэх

7.1.Шийдвэр гүйцэтгэгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.3, 189.7, 189.9-д заасан саналд дараах бичиг баримтыг хавсарган прокурорт хүргүүлж, шүүхээр шийдвэрлүүлнэ:

7.1.1.албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтын биелэлт хангагдсан эсэх тухай тодорхойлолт;

7.1.2.албадлагын арга хэмжээ авагдсан хүнийг хараа хяналтандаа байлгахаар авсан иргэн байгууллага, албан тушаалтан, хамт олны төлөөлөгчийн дүгнэлт;

7.1.3.холбогдох эрх бүхий байгууллагаас Зөрчлийн тухай хуульд заасан арга хэмжээ авагдсан эсэх талаарх лавлагаа, тодорхойлолт;

7.1.4.бусад

Найм. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дуусгавар болгох

8.1.Шийдвэр гүйцэтгэгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 193 дугаар зүйлийн 193.1-т заасан үндэслэлээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дуусгавар болсонд тооцож, тогтоол гарган, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийг хаана.

8.2.Энэ зүйлийн 8.1-д заасан үндэслэлээр дуусгавар болсон тухай шийдвэрийн хувийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийн 193 дугаар зүйлийн 193.2-т зааснаар хүргүүлнэ.

Ес. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний тоо бүртгэл хөтлөх, тайлан тэнцэл гаргах

9.1.Ахлах шийдвэр гүйцэтгэгч тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний талаарх нэгдсэн бүртгэл хөтлөн, мэдээ, тайлан тэнцлийг нэгтгэх бөгөөд тухайн газар, хэлтсийн дарга хяналт тавина.

9.2.Албадлагын арга хэмжээ авагдсан хүний тоо бүртгэлийг аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, улсын нэгдсэн тоо бүртгэлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хариуцан хөтөлнө.

9.3.Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь албадлагын арга хэмжээ авагдсан хүний талаарх мэдээ, судалгааг нэгтгэж, харьяа прокурор болон Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд хүргүүлнэ.

9.4.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь улсын хэмжээнд албадлагын арга хэмжээ авагдсан хүний талаарх мэдээ, судалгааг нэгтгэж, Улсын ерөнхий прокурорын газарт хүргүүлнэ.

---oOo---